

# **СУМДАД БАЙГУУЛАГДСАН ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ САЙН ДУРЫН ХЭСГИЙН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛД**

*ГСҮХ-ийн Гамишиг судлалын төвийн секторын эрхлэгч  
дэд профессор, доктор, ахмад Т.Осөхжаргал*

## **Хураангуй:**

*Сумдад байгуулагдсан гол түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн чадавх, эрхзүйн орчныг сайжруулах, үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалтыг бий болгох талаар санал дэвишүүллээ.*

*Түлхүүр уг: гамшигаас хамгаалах сайн дурын хэсэг, гол түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, эрх зүйн зохицуулалт*

## **Оршил**

Сайн дурын үйл ажиллагаа нь харилцан туслалцаа үзүүлэх, өөрийн хөгжлийг дэмжих, хүмүүнлэгийн үйлс, сурталчилгаа зэрэг иргэний оролцооны олон арга хэлбэрээр хэрэгждэг бол сайн дурын үйлдэл нь үер, газар хөдлөлт, ойн түймэр зэрэг байгалийн гамшигт нэрвэгдсэн ард иргэдэд тусlamж үзүүлэх иргэдийн сайн дурын гэнэтийн үйлдэл, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаагаар ихэвчлэн илэрдэг байна. НҮБ-ын зүгээс сайн дурын үйл ажиллагааг “Ашиг орлого, шан харамжийн төлөө зорилго агуулаагүй, хувь хүний өөрийх нь сэтгэл зүрх, хүсэл сонирхолд тулгуурласан чөлөөт сонголт, мөн бусдад буюу нийгэмд ач тустай байх” зэрэг үндсэн шинжүүдээр тодорхойлсон.

Гамшигаас хамгаалах тухай хуулинд сайн дурын үндсэн дээр гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд оролцоо зохих сургалтад хамрагдсан иргэдийг хэлнэ гэж тодорхойлсон. Гамшигаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааны чиглэлээр Гамшигаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Монголын улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуульд болон эдгээртэй нийцүүлэн гаргасан журмуудаар тус тус тодорхойлсон.

Сайн дурын үйл ажиллагаа нийгэмд эерэгээр нөлөөлдөг нь гадны орны туршлагаар нотлогдоод байгаа тул манай улсад энэхүү туршлагыг нэвтрүүлэх асуудал зайлшгүй шаардлагатай байгаа юм. Сумдад байгуулагдсан гол түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн үйл ажиллагааны чадавхыг авч үзэхдээ гадаад орны туршлагыг судалж, манай орны өнөөгийн байдлыг харьцуулан шинжиллээ.

## **Сайн дурын ажиллагааны эрхзүйн орчинд хийсэн шинжилгээ**

Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрхзүйн орчны тухайд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуульд үндэслэн “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, урамшуулал олгох журам”, “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-уудыг мөрдөж байна.

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлал”ын дагуу “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-уудад 7 асуудлаар харьцуулан шинжлэхэд давхардал 1, хийдэл 5, зөрчил 1 байгааг илрүүлж засаж сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн.

*Хүснэгт 1. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааг зохицуулдаг журмын зөрчил, давхардал, хийдэлд хийсэн шинжилгээний дүн*

№	Аргачлал	Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам <i>Шадар сайдын 2018 оны А/24 дугаар тушаал</i>		Нийт
		Заалтын тоо		
1.	Давхардал	1		1
2.	Хийдэл	5		5
3.	Зөрчил	1		1
<b>Зөрчил, давхардал, хийдлийн нийлбэр дүн</b>				<b>7</b>

Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааг зохицуулдаг журмын зөрчил, давхардал, хийдэлд хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд:

**Давхардал:** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 36.4-т “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан бол “Гал түймэртэй түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-ыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны А/346 тушаалаар баталсан байгаа нь нэг журмаар зохицуулж болох асуудлыг 2 журмаар зохицуулж байна.

**Хийдэл:** 1. Монгол Улсын Шадар сайдын 2016 оны А/34 дугаар тушаал баталсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг

журам”-ыг 2018 оны 03 дугаар сарын 13-ны А/24 дугаар тушаалаар шинэчлэн баталсан боловч өмнөх журмыг дагаж гарсан Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны зааврыг шинэчлэн батлаагүй бөгөөд хуучныг дагаж мөрдөх эсэх тухай тодорхой заагаагүй байна. **2.** Эрхзүйн актын зорилго, хамрах хүрээний хувьд “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-уудад Монгол Улсад зонхилон тохиолддог ой, хээрийн түймрийн үед гал түймрийг унтраах үйл ажиллагаанд “Сайн дурын хэсгийн ажилтан” ажиллах чиглэл заагдаагүй байна. **3.** Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журамд ажилтан шалгаруулахдаа ерөнхий шаардлага тавигдаж байна. Гэвч уг журмын 2.1.2-т “гамшигийн үед эрэн хайх, аврах , хор уршгийг арилгах”, 6.1.3-т “гамшиг ослын зөвшөөрөгдсөн бүсэд нэвтрэн үүрэг гүйцэтгэх” гэж тус тус заасан боловч гүйцэтгэх үүргийн хүрээг тодорхой заагаагүй, үүргийн хүрээнд ямар чадвар эзэмшсэн байхыг тодорхой заагаагүй байна. **4.** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.2-т Гамшгаас хамгаалах сургалт явуулах ангиллыг заасан боловч “сайн дурын хэсэг”-ийн ангиллыг орхигдуулсан байна. **5.** Гамшгаас хамгаалах сайн дурын ажилтанд гамшиг ослын үед ажилласан үеийн ажлын хөлс, хоол, унааны зардал тооцож олгоно. Бусад үед буюу гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах гамшигийн дараах хүмүүнлэгийн тусlamж үйлчилгээ, сэргээн босгох урамшуулал олгох зохицуулалтыг тодорхой заагаагүй орхигдуулсан байна.

**Зөрчил:** Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14.1-т “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг орон нутгийн засаг захиргааны санаачилгаар сайн дурын үндсэн дээр нэгдэж, объектын болон ой хээрийн түймрээс урьчилан сэргийлэх, гал түймрийг унтраах чиг үүргийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор хязгаарлагдмал хүрээнд зохион байгуулагдана.” гэж заасныг “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-ын 1.1-т мөн адил заасан боловч 1.2-т “... Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ажилтныг объектийн гал түймэр унтраахаас бусад ажилд дайчилахыг хориглоно.” гэж заасан нь өмнөх заалттайгаа зөрчилдөж байна.

“Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-ын эрх зүйн актын харьцуулалтын талаар ГСХ-ээс 2020 онд гүйцэтгэсэн “Сумдад байгуулагдсан сайн дурын хэсгийн үйл ажиллагааны өнөөгийн байдлын судалгаа”-ны тайлангаас дэлгэрүүлэн харах боломжтой.

## **Гамшигаас хамгаалах сайн дурын хэсгийн чадавхад хийсэн шинжилгээ**



**Зураг 1. Дорнод, Дорноговь аймгийн сайн дурын ажилтны тоо**

Монгол Улсын хэмжээнд Гамшигаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, “Гамшигийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд 2019, 2020 оны эхний хагас жилд орон нутгийн хэмжээнд гамшигаас

хамгаалах, гал түймэртэй тэмцэх чиглэлээр улсын хэмжээнд 486 сайн дурын хэсэг үүнээс орон нутагт 268 сайн дурын хэсэг, сайн дурын хэсгийн нийт 4876 гишүүд ажиллаж байна.<sup>1</sup> Энэ тоогоор авч үзвэл Монгол Улсын хүн амын 0.16% гамшигаас хамгаалах сайн дурын гишүүд байна гэж үзэхээр байна. Орон нутгийн Засаг даргын захирамжаар байгуулсан Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг 117, Гамшигаас хамгаалах сайн дурын хэсэг 80, Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг болон Гамшигаас хамгаалах сайн дурын хэсэг хамт байгуулсан 71 байна. Судалгааны ажлын хүрээнд Дорнод, Дорноговь аймгийн тус бүр 3, нийт 6 сумаас судалгаанд оролцсон оролцсон 57 сайн дурын ажилтнаас асуулга авч боловсруулсан. Судалгаанд оролцсон Дорнод аймгийн Дашибалбар суманд тус сумын Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/37 дугаар тушаалаар “Гамшигаас хамгаалах болон Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг”-ийг 15 хүн, Халх гол суманд тус сумын Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/28 дугаар тушаалаар “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг”-ийг 15 хүн, Хэрлэн суманд тус сумын Засаг даргын 2019 оны 03 дугаар 14-ний өдрийн тушаалаар “Гамшигаас хамгаалах болон Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг”-ийг 15 хүний бүрэлдэхүүнтэй тус тус байгуулсан бол Дорноговь аймгийн Сайншанд, Айраг, Замын-Үүд сумдад “Гамшигаас хамгаалах сайн дурын хэсэг”-ийг 2019 онд тус бүр 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах, Гамшигаас хамгаалах сайн дурын ажиллагаа нийтлэг журмын хавсралтад заасан гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэгт зайлшгүй байвал зохих зориулалтын автомашин, багаж

<sup>1</sup> ОБЕГ. “Гамшигаас хамгаалах сайн дурын хэсэг”-т зохион байгуулсан сургалт, 2019 он 2020 оны эхний хагас жилийн тайлан, судалгаа. УБ., 2020, 40х

хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалтыг баталсан байдаг нь тухайн үйл ажиллагааг явуулах, хөдөлмөр хамгааллыг хангах нь зайлшгүй шаардлагатай юм.

*Хүснэгт 2. “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах” журмын хавсралтад заасан гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэгт байх гал унтраах зориулалтын автомашин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн харьцуулалт*

№	Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэгт байвал зохих тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл жагсаалт	Байвал зохих тоо хэмжээ /ширхэг/	Байвал зохих зүйлд өгөх оноо	Сумдын гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ашиглаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн тоо				Сумдын гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн тоог төхөөрөмж, багаж харьцуулалт
				Дорнод	Дорноговь	Айраг		
1	Гал унтраах зориулалтын автомашин /усны сав 2000 л/	1 ш	5 оноо	Халхгол	Хэрлэн			0%
2	Усны чиргүүл /Усны сав 1000 л+/-	1 ш	5 оноо					0%
3	Зөөврийн мотопомп	1 ш	5 оноо		5			16.7 %
4	Хөдөлмөр хамгааллын хувцас	10 иж бурдэл	5 оноо /н-0,5/					0%
5	Хорт хий утаанаас хамгаалах баг	3 ш	5 оноо /н-1,6/					0%
6	Гурав сунадаг шат	1ш	5 оноо					0%
7	Довтолгооны шат	1 ш	5 оноо					0%
8	Эвхдэг шат	1 ш	5 оноо		5			16.7 %
9	Галын хоолой	51 мм 2ш	5 оноо /н-2,5/					0%
		20 м 2ш	5 оноо /2,5/					0%
		66 мм 1ш	5 оноо					0%

		20 м 1 ш	5 оноо								0%
10	Хушуу РС- 50	2 ш	5 оноо /н-2,5/								0%
11	Салаа билчэр	1 ш	5 оноо								0%
12	Шилжүүлэн гайк /51 мм, 66 мм/	2 ш	5 оноо /н-2,5/								0%
13	Гэрэлтүүлэг	1 ш	5 оноо								0%
14	Царил	3 ш	5 оноо /н-1,6/								0%
15	Хүрз	2 ш	5 оноо /н-2,5/	5	5	5	5	5	5	5	100 %
16	Багор	1 ш	5 оноо								0%
17	Хоолойн нөхөөс	2 ш	5 оноо /н-2,5/								0%
18	Аврах олс /20 м урттай/	1 ш	5 оноо				5				16.7 0%
19	Хөрөө	1 ш	5 оноо								0%
20	Гар хөрөө	1 ш	5 оноо								0%
Тухайн сайн дурын хэсгийн зайлшгүй байвал зохих тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хангалт %		40 ш	100 оноо	5 %	5 %	1 5 %	1 0 %	5 %	5 %	$\bar{x}$ $= \frac{1}{n} \sum_{i=1}^n x_i$ $= 7.5\%$	

(Жич: Арифметик дундажийн утгыг  $= \bar{x}$ , Түүврийн хэмжээ  $= n$ ,  
санамсаргүй хэмжигдэхүүний  $i$  дугаар  $= x_i$ )<sup>2</sup>


Харьцуулсан хүснэгтийн үр дүнгээр түүврийн судалгаанд хамрагдсан б сумын сайн дурын хэсгийн зайлшгүй байвал зохих тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хангалт 7.5% -тай байгаа нь туйлын хангалтгүй байна.

Дорнод аймгийн 3 сумдад тухайн орон нутгийн Засаг дарга “Гамшигаас хамгаалах болон Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг” гэж давхардуулан байгуулсан боловч Дорноговь аймгийн сайн дурын хэсгээс багаж хэрэгслийн хувьд ялгагдах зүйлгүй байгаа нь энэ журмын хэрэгжилт тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хангалт ялгаагүй маш хангалтгүй түвшинд байна. Мөн асуулгаар тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хангалттай эсэх талаар асуухад “хангалтгүй” гэсэн үнэлгээг нийт оролцогчдын 56,3%, 33.3% нь дунд зэрэг,


<sup>2</sup>[http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Статистикийн\\_тоон\\_мэдээллийг\\_ашиглан\\_дүн\\_шинжилгээ\\_хийх\\_\\_үндсэн\\_арга\\_техникийд.pdf&ln=Mn](http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Статистикийн_тоон_мэдээллийг_ашиглан_дүн_шинжилгээ_хийх__үндсэн_арга_техникийд.pdf&ln=Mn)

10.4% нь хангалттай гэж үнэлжээ. Үүнээс Дорноговь аймаг хүч хэрэгсэл хангалттай эсэхэд нийт хамрагдсан ажилтны 70% “хангалтгүй” үнэлгээг хамгийн их өгсөн бол Дорнод аймгийн гишүүд 46% нь тус үнэлгээг өгсөн байна. Үүнийг Сайн дурын хэсгийн хангалт “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах” журмын хавсралтад заасан гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэгт байх гал унтраах зориулалтын автомашин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хангасан үзүүлэлттэй дүйцүүлэн харахад мөн адил маш “хангалтгүй” 70% байгаа нь нийт орон нутгийн сайн дурын ажилтны хөдөлмөр аюулгүй ажиллагааг хангах хувцас хэрэгсэл хангалтгүй байгааг харуулж байна.

Түүврийн аргаар 6 сумдын сайн дурын хэсгийн нийт 57 албан хаагчдаас аюул, ослын дуудлагаар хэдэн удаа ажилласан, сайн дурын гишүүдийн сургалт авсан байдал, цаашид шаардлагатай сургалт, сайн дурын гишүүдийн ашиглаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд өгөх үнэлгээ, шаардлагатай багаж хэрэгсэл, шийдвэрлүүлэх саналыг асуухад дараах байдалтай хариулсан байна.



Зураг 2. Дорнод, Дорноговь аймгийн 6 сумын сайн дурын хэсгийн гишүүдийн тоо, дуудлагаар ажилласан байдал




### Зураг 3. Сүмдүн сайн дурын хэсгийн дуудлагаар ажилласан байдал

Дуудлагаар ажилласан байдлыг “Сүмдүн сайн дурын хэсэг” газарзүйн өөр байршил болон “Дуудлагаар ажилласан тоо”-нд Хи квадрат (Chi square) шинжилгээ хийхэд 0.5-аас бага гарсан байгаа тул сумдын сайн дурын хэсгүүд дуудлагаар ажилласан байдал ялгаатай байгааг харуулж байна. Эндээс дүгнэн үзвэл Дорнод аймгийн гал түймрийн тохиолдол Дорноговь аймгаас эрс өндөр байгаа нь сайн дурын хэсгийн ажилтнуудын дуудлагаар ажилласан тоонд шууд нөлөөлсөн байна.

Асуулгын судалгаанд Дорнод аймгаас оролцсон ажилтнуудын 8.2 хувь нь дуудлагаар ажиллаж байгаагүй бол энэ үзүүлэлт Дорноговь аймгаас асуулгад оролцсон ажилтнуудын 80 хувь нь дуудлагаар ажиллаагүй байна.

### Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн чадавхыг сайжруулах зарим асуудал (Зураг 4, 5)

Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллагааны чиглэлээр 3 журам 1 заавар өнөөдөр мөрдөгдөж байна. Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрхзүйн орчны тухайд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуульд үндэслэн “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, урамшуулалт олгох журам”, “Гал түймэртэй тэмцэх



14-р зураг. Сайн дурын хэсгийн эрхзүйн орчны өвлийн байдал

15-р зураг. Цаашид сайн дурын хэсгийн эрхзүйн орчны нээгдэл болгох санал

#### Тэмдэглэгээ



Шинээр бий болгох

Шинэчлан найруулах

сайн дурын хэсэг ажиллуулах журам"-уудыг мөрдөж байна. Хууль зүй дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлал”ын дагуу шинжлэхэд “Гамшигаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-уудад 7 асуудлаар харьцуулан авч үзэхэд давхардал 1, хийдэл 5, зөрчил 1 байгааг илрүүлж засаж сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн. Гамшигаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллагааны эрхзүйн орчныг нэгдмэл болгох дараах саналыг судалгааны ажлын үр дүнгээр тодорхойлж байна.

Гамшигаас хамгаалах тухай хууль болон Галын аюулгүй байдлын тухай хуулийг үндэслэн “Гамшигаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-ыг шинээр шинэчлэн батлуулах шаардлагатай. Шинэчлэн батлуулсан “Гамшигаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-ыг үндэслэн “Гамшигаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар”-ыг мөн шинэчлэн боловсруулж батлуулах санал оруулж байна.

Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам нь оновчтой тодорхой боловч журамд биш зааварт оруулж болохоор үйл ажиллагааны чиглэлийн зааварчилгаа, хавсралтаар хүснэгтүүдийг шинээр найруулах гамшигаас хамгаалах сайн дурын ажиллагааны зааварт оруулах саналтай байна.

Олон улсын туршлагаас үзэхэд дэлхийн 59 улсад нийт 15.4 сая гал сөнөөгчид ажиллаж байгаагийн 13.9 сая буюу **90** орчим хувь нь сайн дурын гал сөнөөгчид гал түймрийн дуудлагын ихэнх тохиолдолд ажиллаж байна. АНУ-ын Гал түймэртэй тэмцэх байгууллага нь Гал түймэртэй тэмцэх үндэсний сайн дурын зөвлөлтэй сайн дурынхны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, сайн дурын үйлчилгээг чанартай сайн үзүүлэх дотоодын сайн дурын байгууллагыг дэмжиж ажилладаг<sup>3</sup>. Сайн дурын гал сөнөөгч нь Гал түймэртэй тэмцэх сайн дурын мэргэшсэн байгууллагад харьялагдаж нийгмийн баталгаагаа хангулдаг байна. Монгол улсын хувьд гамшигаас хамгаалах сайн дурын нийтлэг журмыг үндэслэн Гамшигаас хамгаалах сайн дурын мэргэшсэн байгууллага эсвэл гамшигтай тэмцэх үндэсний сайн дурын зөвлөлийг байгуулж энэ зөвлөл нь гадаад хамтын ажиллагаа төсөл, хөтөлбөр, бодлого хэрэгжүүлэх болон дотоодын төв орон нутаг дах сайн дурын байгууллагыг идэвхтэй дэмжиж ажилладаг байхаар санал дэвшүүлж байна. (Зураг 15)

---

<sup>3</sup> <https://www.nvfc.org>

Өндөр хөгжилтэй улс орнуудын адил сайн дурын ажилтны нийгэмд эзлэх байр суурийг нь өндөрт тавьж, нийгмийн халамж, үйлчилгээ болон гадаад дотоод сургалтын тэтгэлэг, их сургуульд элсэх, ажилд орох зэрэгт нь дэмжлэг болох эрхзүйн орчныг бүрдүүлж өгөх шаардлагатай байна. Эрхзүйн орчныг бүрдүүлэхдээ дараах зүйлийг харгалzan үзэж тусгах:

- Тухайн сум орон нутгийн аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо давтамжийг сайн дурын хэсгийн ажилтны тоотой уялдуулж гаргах;
- Олон улсын туршлагаас харахад гал түймэртэй тэмцэх сайн дурын ажилтны эмэгтэйчүүдийн эзлэх хувь дунджаар 15-20 хувьтай байгааг харгалzan Монгол орны онцлогт тохируулан оновчтой тоог тогтоох.
- Сум орон нутгийн гамшигийн эрсдэлийн үнэлгээ, гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд үндэслэн гамшигаас хамгаалах сайн дурын хэсгийн бүтэц зохион байгуулалт, төсөв санхүү, сургалтыг асуудлыг уялдуулан төлөвлөж Сумын засаг даргын үр дүнгийн жилийн ажлын төлөвлөгөөнд оруулах.
- Гамшигаас хамгаалах сайн дурын хэсэгт тогтвортой суурьшилтай /3-аас дээш жил/, үр бүтээлтэй ажилласан иргэнийг Засаг даргын тодорхойлолтоор онцгой байдлын албандаа дэвшүүлэн ажиллуулах саналыг Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэх эсвэл тухайн орон нутгийн зүгээс хүндэтгэл үзүүлж цалингийн доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулалт олгож алдаршуулах.

## Дүгнэлт

Сайн дурын үйл ажиллагаа нь харилцан туслалцаа үзүүлэх, өөрийн хөгжлийг дэмжих, хүмүүнлэгийн үйлс, компанийт сурталчилгаа зэрэг иргэний оролцооны олон арга хэлбэрээр хэрэгждэг бол сайн дурын үйлдэл нь үер, газар хөдлөлт, ойн түймэр зэрэг байгалийн гамшигт нэрвэгдсэн ард иргэдэд тусlamж үзүүлэх иргэдийн сайн дурын гэнэтийн үйлдэл, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаагаар ихэвчлэн илэрдэг байна.

Гамшигаас хамгаалах тухай хуулийн 36.4 дэх заалтад “Гамшигаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллах журмыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан бол “Гал түймэртэй түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-ыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/346 дугаар тушаалаар баталсан байгаа нь нэг журмаар зохицуулж болох асуудлыг 2 журмаар зохицуулж байгааг залруулж цаашид нэгдмэл үйл ажиллагааны нийтлэг нэг журамтай байх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Шадар сайдын 2016 оны А/34 дугаар тушаал баталсан “Гамшигаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-ыг 2018 оны 03 дугаар сарын 13-ны А/24 дугаар тушаалаар шинэчлэн баталсан боловч өмнөх журмыг дагаж гарсан Гамшигаас хамгаалах сайн дурын ажиллагааны зааврыг шинэчлэн батлаагүй бөгөөд хуучныг дагаж мөрдөх эсэх тухай тодорхой бус байгааг засч залруулж шинээр заавар шинэчлэн батлуулах шаардлагатай.

Монгол улсын хувьд цаашид гамшигаас хамгаалах сайн дурын нийтлэг журмыг үндэслэн Гамшигаас хамгаалах сайн дурын мэргэшсэн байгууллага эсвэл гамшигтай тэмцэх үндэсний сайн дурын зөвлөлийг байгуулж энэ зөвлөл нь гадаад хамтын ажиллагаа төсөл, хөтөлбөр, бодлого хэрэгжүүлэх болон дотоодын төв орон нутаг дах сайн дурын байгууллагыг идэвхтэй дэмжиж ажилладаг байхаар санал дэвшүүлж байна.

Сумын сайн дурын хэсгийн зайлшгүй байвал зохих тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хангалтыг нэмэгдүүлж стандартын шаардлагад хүргэх хэрэгтэй.

#### **Ашигласан эх сурвалж**

1. Монгол Улсын Гамшигаас хамгаалах тухай хууль, УБ., 2017.
2. Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хууль, УБ., 2015.
3. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 24 дүгээр тушаал, “Гамшигаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”.
4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны А/346 дугаар тушаал, “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”.
5. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 38 дугаар тушаал, “Гамшигаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, урамшуулал олгох журам”.
6. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/185 дугаар тушаал, “Гамшигаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар”.
7. Гамшиг судлалын хүрээлэн. Сумдад байгуулагдсан сайн дурын хэсгийн үйл ажиллагааны өнөөгийн байдлын судалгаа., УБ., 2020.
8. ОБЕГ-ын Гамшигаас урьдчилан сэргийлэх газар, “Гамшигаас хамгаалах сайн дурын хэсэгт зохион байгуулсан сургалт. 2019, 2020 оны эхний хагас жилийн тайлан, судалгаа”, УБ., 2020
9. ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газар, “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн судалгаа”, УБ., 2020
10. Victoria Bushfire Royal Commission, 2010, Final Report-2009
11. National Volunteer Fire Council, 2018, Volunteer Fire Service Culture: Essential strategies for success